

БАЯНХОНГОР АЙМГИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД 2021 ОНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2022 оны 03 дугаар сарын 28

Номгон


Тайлант онд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд хүлээж буй үр дүнд хүрч хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох, хэлтэс, агентлаг, сумдын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд гарч буй ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, зөрчил дутагдлыг засч залруулах, шийдвэр гаргах үйл ажиллагааг бодит байдал, нотлох баримтад тулгуурласан байхад чиглүүлэх, бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмжөөр хангах зорилгоор хяналт шинжилгээ, үнэлгээг хийсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгон үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнгийн талаар орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж, www.unelgee.gov.mn цахим санд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллалаа.

**Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ,
үнэлгээний талаар:**

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 17 заалтын хэрэгжилт, явц, үр дүнд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээр үр дүнтэй буюу 100 хувь хэрэгжсэн-5, 90 хувь хэрэгжсэн-4, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь хэрэгжсэн-7, эрчимжүүлэх шаардлагатай буюу 30 хувь хэрэгжсэн-1 зорилт, арга хэмжээ байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр дундаж хэрэгжилт 81.18 хувьтай дүгнэгдлээ. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2020, 2021 оны эхний хагас жил, 2021 оны жилийн эцсийн байдлаар 3 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хэрэгжилтийн үнэлгээ



Зөвлөмж:

1.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээний заалт бүрийг бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн тус бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;


2.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.9 дэх заалтад тусгагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар холбогдох газруудтай хамтран ажлыг эхлүүлэх;

3.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жигд ханган биелүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж, тайланг хяналт шинжилгээ, үнэлгээний журмын дагуу улирал тутам ирүүлж байх;

4.Гарсан үр дүнг товч, тодорхой бичиж, цаг хугацаанд нь тайлагнах;

Хоёр. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бодлого, 156 зорилтын хүрээнд 337 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 39.2 хувьтай байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 89.78 хувь дүгнэгдсэн байна.

**Өгсөн зөвлөмж:**

1.Зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлон, хэрэгжилтийн тайланг гарсан үр дүнгээр, оновчтой зөв тайлагнах;

2.Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрыг мэргэжил, арга зүйгээр хангах;

3.Зорилт, арга хэмжээний хэрэгжилтээр гарсан үр дүнг тооцож байх;

4.Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрүүдийн үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

Гурав. Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:

Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж нэгтгэн үзэхэд 62.24 хувьтай байна.

Өгсөн зөвлөмж:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөтөлбөрийг боловсруулж, батлуулах;

2. Суурь түвшин, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулан зөв тодорхойлох;

3. Суурь түвшингийн судалгааг 2021, 2022 оноор, 2022, 2023, 2024 онд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг боловсруулах;

4. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах ажлыг чанартай зохион байгуулан, оновчтой, үр дүнд суурилсан тайланг хугацаанд нь ирүүлэх;

5. Бодлогын хэлтсүүдийн албан хаагчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх;

6. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд аймгийг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөөний холбогдох заалтыг бүрэн тусгаж, хэрэгжилтийг хангуулж ажиллах;


7. Зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний дэс дугаар, эрэмбэ дарааллыг цэгцлэх;

8. Хэрэгжилт хангалтгүй зорилт, арга хэмжээнүүдийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажлыг эхлүүлэх;

9. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;

Дөрөв. Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилт 2021 оны эхний хагас жилийн байдлаар 35.0 хувьтай байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 80 хувь болж өссөн байна.




Өгсөн зөвлөмж:

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг чанартай зохион байгуулан, судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан үнэн зөв, оновчтой, үр дүнд суурилсан тайланг хугацаанд нь ирүүлэх;

2.Тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн хяналтад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний ахиц өөрчлөлтийн чанарын болон тоон мэдээллийг хөтөлж хэвших, хэрэгжилтийн явцыг бус үр дүнг чухалчлан тайлагнаж байхыг зөвлөж байна.

Тав. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаар:

Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд 5 бүлэг, 135 ажил, арга хэмжээ төлөвлөн ажилласнаас хэрэгжилт 87,89 хувьтай үнэлэгдсэн.

**Өгсөн зөвлөмж**

1.Арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг оновчтой, зөв, тухайн жилдээ бүрэн хэрэгжихүйц байдлыг судалж тодорхойлох;

2.Ажил, арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийг хаанаас санхүүжүүлсэн, тухайн жилд ямар хэмжээнд төсөвлөсөн, гүйцэтгэл хэдэн хувьтай зэргийг тодорхой тайлагнах;

3. Хэрэгжилтийг тайлагнахдаа үйл ажиллагааг бус үр дүнг тодотгож тайлагнахыг удаа дараа зөвлөмжөөр хүргүүлсэн боловч давтагдсаар байгаад анхаарч ажиллах;

4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.8-т тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана гэж заасныг мөрдлөг болгох нь зүйтэй боловч тайлан

хэт ерөнхий товч байх нь зохион байгуулсан ажил, арга хэмжээ, үр дүн нь тодорхой харагдахгүй байгааг анхаарч тайлагнах;


5. Арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин хүрсэн түвшинтэй харьцуулан бодит үнэлгээ өгөх;


6. Албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа нотолгоонд тулгуурлан тайлангийн хэрэгжилтийг үнэн зөв тайлагнах, ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудад анхаарч ажиллах;

7. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд бодит судалгаа, нотлох баримтад тулгуурлан бүрэн гүйцэт, оновчтой тайлагнах;

Зургаа. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний талаар:

Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрийн 2020 оны хэрэгжилтэд 2021 оны 01 дүгээр сард, 2021 оны хагас жилийн хэрэгжилтэд 2021 оны 07 дугаар сард, 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд 2022 оны 01 дүгээр сард хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа.





Монгол Улсын Засгийн газрын 2021 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах зөвлөмжийг хүргүүлсэн.

1.Бодлогын хэлтсүүд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа bayankhongor.igovernment.mn цахим санд заасан хугацаанд тайлагнах, Монгол хэлний тухай хууль, тогтоомжийг мөрдөн зөв бичих дүрэм, найруулга зүйн алдааг нягтлан шалгаж байж баталгаажуулах;

2.Шийдвэр, заалтыг нэг бүрчлэн шүүн үзэж хэрэгжилт тогтмолжсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, нэг удаагийн шинжтэй заалтуудыг хяналтаас хасах саналыг, үндэслэлийн хамт ирүүлж хэвших;

3.Хэлтсийн дарга нар тайлангийн хэрэгжилтэд ач холбогдол өгч хяналт тавьж, баталгаажуулах;

4.Төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах;

5.Тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн хяналтад авч хэрэгжүүлж буй арга хэмжээний ахиц өөрчлөлтийн чанарын болон тоон мэдээллийг хөтөлж хэвших, хэрэгжилтийн явцыг бус үр дүнг чухалчлан тайлагнаж байх;

6.Төрийн албан хаагчдад баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт нотолгоонд тулгуулан үнэн зөв, оновчтой тайлагнах ур чадварыг эзэмшүүлэхэд анхаарах;

7.Бодлогын хэлтсийн мэргэжилтнүүд холбогдох агентлаг сумдаас ирсэн тайланг шууд хуулж тавих бус бодлогын түвшинд нэгтгэн боловсруулалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох дээд шатны байгууллагад санал уламжлан асуудлыг шийдвэрлүүлэх зэрэгт бүтээлч байдлаар хандаж ажиллах;

Долоо. Аймгийн Засаг дарга Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний талаар:

Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын 15 гишүүн Ерөнхий сайд, Шадар сайд, Байгаль орчин, аялал, жуулчлалын, Батлан хамгаалахын, Сангийн, Хууль зүй,

дотоод хэргийн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Барилга, хот байгуулалтын, Боловсрол, шинжлэх ухааны, Зам, тээврийн хөгжлийн, Соёлын, Уул уурхай, хүнд үйлдвэрийн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Эрчим хүчний, Эрүүл мэндийн сайд зэрэг Засгийн газрын гишүүд. Үндэсний хөгжлийн газартай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг дунджаар 90.6 хувь ханган биелүүлсэн байна.

Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг тус бүр дүгнэн, холбогдох яаманд тайланг хүргүүлж, зөвлөмж өгч ажилласан.

Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний үнэлгээг доорх зурагт тус бүрээр үзүүлээ.



Найм, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар:

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн тайланд тусгагдсан 22 зорилт, 83 арга хэмжээний 90.4 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 1.2 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 8.4 хувь нь үр дүнд хүрээгүй байна. Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилт 87.2 хувьтай үнэлэгдлээ. Үнэлгээг зургаар илэрхийлбэл:



Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн тайланд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдээс зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, жишиг болох үр дүн гарсан ажлууд олон байна. Тухайлбал:

1. Байгууллагын албан хаагчдын ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны чанар хүртээмж, ил тод байдлыг сайжруулах зорилтын хүрээнд Нэгдсэн эмнэлэг үзлэгийн номер тараалтын 1800-1109 дугаарыг ажиллуулж эхэлсэн нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайжирсан нэгэн үзүүлэлт болсон байна.

2. Цахим технологид тулгуурлан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд иргэдийн 14-30 хоногт авдаг үйлчилгээг 7-14 хоногт, нэг удаагийн үйлчилгээ авах хугацаа 4-5 минут болж багасгасан.

3. Цахим технологид тулгуурлан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд аймгийн үзэсгэлэнт газруудад виртуал аялал хийх боломжийг бүрдүүлж, орчин үеийн стандарт, техник технологийн дэвшилд нийцсэн 250 сая төгрөгийн өртөг бүхий виртуал Баянхонгор төвийг шинээр байгуулсан.

4. Монгол Улсын гадаад бодлогод нийцүүлэн холбооны гишүүн орнуудтай харилцаа холбоогоо улам өргөжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлж, худалдаа эдийн засгийн харилцааг шинэ түвшинд хүргэх зорилтын хүрээнд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, аялал жуулчлалын салбарт Японы "Өвсний үндэс" хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр "Ger and Nature" (гэр ба байгаль) аялал судалгааны төсөл хэрэгжиж эхэлсэн.

5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, бүртгэл лавлагааны сан бүрдүүлэх, хууль тогтоомжийн лавлагаагаар байгууллага, иргэд хуулийн этгээдэд үйлчлэх, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг хянах, бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих зорилтын хүрээнд Эмнэлгийн болон сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээнд 250.0 сая/төг-ийг зарцуулан, 120 иргэнийг эмчилж, урьдчилсан

үр дүнгээр 75 хувь нь архинаас бүрэн татгалзаж, тогтворжуулах эмчилгээнд хамрагдаж, 25 хувь нь дахилт өгч давтан эмчилгээнд хамрагдаад байна. Мөн говийн 8 сум, хангайн 2 сумд ажиллаж сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Эмчилгээнд хамрагдсан 70 иргэн архинаас бүрэн татгалзсан.

6. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих зорилтын хүрээнд 2021 оны А/95 дугаар захирамжаар 5.0 сая/төг зарцуулж, иргэд лавлагаа мэдээллийн үйлчилгээг тоон гарын үсгээр цахимаар авах бүрэн боломж бүрдэж бусад аймаг, хотоос онлайн тоон гарын үсгээр 136 иргэн лавлагаа авч, нийт баримтын 50 хувийг ашигласан зэрэг олон арга хэмжээ бодит үр дүнд хүрсэн байна.

Зөвлөмж:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;

2. Зорилт, арга хэмжээний суурь түвшин, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдуулан зөв тодорхойлох, суурь түвшинг судалгаанд үндэслэн, хүрэх түвшинг бодитой тодорхойлон боловсруулах, хэрэгжилтийн тайланг гарсан үр дүнгээр, оновчтой зөв тайлагнах;

3. Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд тасарсан судалгаанууд болон "Төрийн мэргэшсэн албан хаагч" хөтөлбөр боловсруулах, Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах зэрэг ажлуудыг 2022 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

Ес. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах чиглэлээр:

Орон нутгийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, гүйцэтгэлийн тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээх зорилго бүхий аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэх ажлыг санаачлан 45.000.000 (дөчин таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэн, "Ухаалаг засаглал" төрийн бус байгууллага тендерт шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус цахим санд бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн зорилт, арга хэмжээг байршуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрыг холбон тайлан мэдээллийг авч, ажиллаж байна.

Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, удирдах албан тушаалтнуудын фото зураг, ажлын чиг үүрэг болон бодлогын хэлтсүүдийн зорилго, зорилт, албан хаагчдын хариуцсан ажлын чиг үүргийг фото зургийн хамт танилцуулгын самбарт ил тод мэдээлдэг.

Түүнчлэн, аймгийн албан ёсны <https://bayanhongor.gov.mn/> цахим хуудсанд эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан, байнга шинэчилж, баяжуулах зэргээр хөтлөн явуулж байна.

Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнээс нийт 850 мэдээ, мэдээлэл бэлтгэж вэб сайт болон фэйж хуудаст нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг гэрээт 3 телевиз, "Өнөөгийн Баянхонгор" сонин, "Монцамэ" агентлагийн вэб сайтад давхардсан тоогоор 1200 удаа мэдээ нийтлүүлж ажилласан.

E-Mongolia төслийн операторын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт "Үйлчилгээний нэгдсэн төв"-өөр 2021 онд 54 төрлийн үйлчилгээг 3682 иргэнд хүргэсэн байна. E-Mongolia цахим үйлчилгээнд 400 гаруй иргэнийг шинээр бүртгэж, иргэдийн 14-30 хоногт авдаг үйлчилгээ 7-14 хоногт, нэг удаагийн үйлчилгээ авахад 10-15 минутын хугацаа шаарддаг байсан бол 4-5 минут болж багассан. Тайлангийн хугацаанд Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс 10254 иргэнд, Улсын бүртгэлийн хэлтэс 6853 иргэнд, Газрын асуудлаар 8728 иргэнд, Хууль зүйн туслалцааны төв 36 иргэнд өмгөөллийн, 268 иргэнд хууль зүйн зөвлөгөө мэдээллийг хүргэн нийт 26139 иргэнд нэг цэгээс түргэн шуурхай, нээлттэй үзүүлсэн байна.

Мөн коронавирусын цар тахлын үед иргэд, ААН-ээс аймгийн Онцгой комисст мөнгөн болон эд материалын хандив тусламжийн хэмжээг иргэд, олон нийтэд тухай бүр нээлттэй мэдээлж, хандивлагч иргэд, ААН-дэд зориулж "Хандивлагчиддаа баярлалаа" 3 удаагийн талархлын контентыг бэлтгэж, "Нээлттэй засаг-Нэг Баянхонгор" фэйж хуудсаар цацаж, давхардсан тоогоор 180 гаруй мянган иргэнд хүргэсэн.

Төрийн албаны сул орон тоо, түүнийг нөхөх шалгалтын тов зэргийг цахим хуудас, "Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл", "Нээлттэй Засаг-Нэг Баянхонгор" цахим хуудсаар дамжуулан тухай бүр иргэд, олон нийтэд хүргэж ажилласан байна.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлэх үнэлгээний баг 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/192 дугаар тушаалаар шинэчлэгдэн байгуулагдаж, холбогдох саналыг төсвийн шууд захирагчид уламжлан шийдвэрлэсэн мэдээллийг www.bayanhongor.gov.mn цахим хуудаст байршуулж мэдээлсэн.

Арван нэг. Сургалт, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 2, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, төрийн албанд анх томилогдсоны дараах сургалтад 3, Удирдлагын академийн богино хугацааны зорилтод сургалтад 10, Засгийн газрын зорилтод 2 удаагийн сургалтад төрийн захиргааны 41 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн байгууллагын албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм, холбогдох хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран цахимаар зохион байгуулсан. Албан хаагчдын 73,8 хувь нь мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлийн дотоод сургалтад хамрагдсан.

Мэргэшсэн 4 албан хаагч буюу нийт мэргэшсэн албан хаагчдын 9.7 хувь нь шилжсэн байна.

Байгууллагын хамтын гэрээ, дотоод журамд заагдсан нэг удаагийн тусламж, дэмжлэгийг тухай бүр шуурхай шийдвэрлэж нийт 34.967.000 төгрөг, мөн албан хаагчдын сургалт хөгжил, урамшуулал, хоол унааны нэмэгдэл, томилолт, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зардал зарцуулж, албан хаагчдын нийгмийн асуудалд нийт 130.251.000 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цалингийн зардал тусгагдаагүй.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн, эдийн засгийн нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн дүнг хавсаргав.